

МОНГОЛЧУУДЫН АЖ ТӨРӨХ ЁСНЫ  
ХЭМЖИГДЭХҮҮНИЙГ ИЛЭРХИЙЛЭХ БАЙДАЛ

А.Пүрэвжанцан

Түлхүүр үг: *range time, hard and easy, lot and less, long and short*

Хэл шинжлэлийн салбар ухаан улам бүр гүнзгийрэн тэлж аливааг ганц хэл зүйн үүднээс бус угсаатны зүй, сэтгэл судлал, математик, соёл судлал зэрэг олон салбар ухаантай уялдуулан судлан шинжилж, харьцуулалт хийдэг болжээ. Юмс үзэгдлийн мөн чанарын тоон утгыг ойлгоход ямар нэгэн хэмжүүрээр илэрхийлдэг. Хэмжүүр гэдэг нь хэм гэсэн үгнээс үүсэлтэй бөгөөд хэм, хэмжээ, хэмжигдэхүүн, хэмжээс, хэмжилт, хэмжих хэмээх олон ойролцоо үгийг төлөөлнө.

Энэ үүднээс монгол хэлийг монгол хүний аж төрөх ёс, түүх соёл, сэтгэхүй сэтгэлгээний онцлогтой холбон монголчууд бид олон зууны тэртээгээс ахуй амьдралын өвөрмөц байдалдаа тохируулан орон зай, цаг хугацаа, хүнд хөнгөн, их бага, урт богино, талбай эзлэхүүн, ахуй байдал, цаг улирлын хэмжээсүүдийг орчин үеийн хэмжүүрийн системд таацуулан дүйлгэдэг.

Монгол хэлний үгийн сан аж төрөх ёс, ахуй байдлыг заасан хэмжээст үгсээр арвин баялаг уламжлалтай юм. Үүнд:

- Гар хуруугаар илэрхийлэх
- Хөлөөр илэрхийлэх
- Биеэр илэрхийлэх
- Малын явдлаар илэрхийлэх
- Цаг хугацааны хэмжигдэхүүнээр илэрхийлэх
- Орон зай, талбайн хэмжигдэхүүнээр илэрхийлэх.

Дээрх хэмжээст илэрхийллүүдийг тодотгох үүднээс заримыг жишээ болгон авч үзье. Тухайлбал:

Монголчууд өөрийн бие эрхтэн, гар хөлөөр жишин харгуулж хэмждэгээрээ өөр аль ч улс үндэстэнд байхгүй, дахин давтагдашгүй, уламжлалт ахуйн соёлтой ард түмэн билээ. Жишээ нь:

“Босоо хүний борвин доогуур

Суугаа хүний суган доогуур” (Хэлц хэллэг)

1920-оод оны сүүлчээр хулгайд алдсан “Дархад гурван отгийн үүсэл, язгуурын үнэн бүрэн түүх” гэдэг ном **хар хумсын хэртэй** зузаан алтан хавтастай байсан тухай аман мэдээ бий. (З.Лонжид “Монголчуудын уламжлалт хэмжүүрийн тухай нэхэн эргэцүүлэхүйн учир) гэх,

Хурц цагаан соёогоо ярзайлган, дарвагар хар завжаа **алд дэлэм** сунган эвшээлгэх зүрхэн дээрээ **алга дарам** бөрт цагаан үстэй азарган чоныг буутай сан бол доор нь нам буудмаар санагдана. (Б.Догмид “Босоо ороолон”) эсвэл,

Би ээжийн дуранг нууж аваад хойд овоон дээр гарч харвал, нээрээ л нуурын дунд ганц хонгор адуу шиг юм үзэгдэж, Мэнд эгч шүхрээ барин, хормойгоо шуугаад нуурын захын лаг шаварт **борвиороо татгал** шигдсэн хөлөө дээр өргөж явах нь цэн тогоруу шиг байлаа. (Б.Догмид “Мэнд эгч”) бүр бөгөөтөл,

“Энэ жаахан **бөгс эргэх зайгүй** эмнэлэгт байтугай эрлэг номун хааны өргөөнд бараалхсан ч зэрэг дэвээрээ дээгүүр морилж гэмээ нь дээгүүр суудалтай архичин хэмээн бодож очсон маань даанч эндүүрэл юм санж.” Б.Догмид “Хөх тайгын үлгэр” дахин,

**“Хөл нь дөрөөнд хүрэх**

**Гар нь ганзаганд хүрэх”**

гэхчлэн тус тус харгуулан жишиж, харьцуулан хэмжих ажээ.

Малчин түмэн маань “малынхаа амьсгаанаас бусдыг ашигладаг” гэдэгчлэн зуу зуун жил эргэх дөрвөн цагийн аясад таван хошуу малаа адгуулан маллаж ирэхдээ түүнтэй холбогдох адууны **бэлчээр газар, азарга адуу, амбан шар шиг, аргал хомоол шиг, богийн туруу, бодын туруу, гүзээ тос, дөрөө шүргэм, жижиг тугалын бэлчих газар, зэлний чинээ, морь хөлслөх газар, суурь хонь, тавхайн чинээ, үхэр тэрэг шиг, хонин тогоон чинээ, ших мах, эмээлийн бүүрэг шиг** гэх мэт олон янзын хэмт үгсийг амьдрал ахуйдаа хэлэлцэн ярилцсаар ирсэн байна. Жишээ нь:

...**Азарга адуугаар** арилжихгүй ийм сайхан буянаа нэг муу утаатай чулуугаар солих гэж байх уу?... (Б.Догмид (Зохиолын түүвэр)) гэх буюу “Хөвчид **дөрөө шүргэм** зузаан цас орсон боловч яг энүүхэн хавьдаа газар хар, хагд өвс халиурна.” (С.Эрдэнэ (Амьдралын тойрог)), мөн “Хүн малын элбэг биш ч гэлээ ямар ч гантайд элгийг нь дэвтээж байсан **тэмээн тавхайн чинээ** ус ширгэн алга болжээ.” (Д.Цэнджав “Хулангийн цавчаал”) мэтсийг тоочиж үл барна.

Зөвхөн цаг хугацааг илэрхийлэхдээ гэхэд **элэр балрын үед, эрт дээр цагт, эрт урьд цагт, урьд нэгэн цагт, урьдын урьд, аль дивангарт, амбасын үед** гэх мэт хаа холын эртнээс эхлэн эдүгээ **өнөөг хүртэлх одоо мөдхөн, сав саяхан, нүд ирмэхийн зуур, цай чанах зуур, хормын дотор, гялсхийх зуур** гэхчлэн жишин хэлэлцсэн нь бишгүй нэг бий. Жишээ нь:

“Аль **дивангарт** зургаан зүйл, хамаг амьтны эх болсон, илэрхий зөөлөн авирт, илтэд хурдан тонилгогч Ногоон дарь эх Яншин сүмд, Дүнжингаравын хийдэд арваас далан долоон насыг хүртэл даяныг бясалган суув.” (Ногоон Дарь эхийн тууж) гэх буюу “Салаа хархан гээгтэй, сурагчийн дүрэмт хувцсаар гангарсан, годгор охин байсан цаг **сав саяхан** даа.” (А.Пүрэвжанцан *Монголчуудын хэмжээ илэрхийлэл*), бас “Зураач Жамба бага залуугаас эхлээд хижээл насыг хүртэл үзэж өнгөрүүлсэн амьдралд нь олон янзын захиалга, үүрэг, гуйлт тохиож байлаа. Зарим нь **цай чанах зуур** бүтээчихмээр, зарим нь зун намрын зургаан сард ч арайхийн бармаар янз янзын юм байж билээ.” (Л.Түдэв “Эрхий дарам зай”) гэхчлэн буй.

Мөн юмны үргэлжлэх хугацааг ахуй байдалтайгаа холбон **хүүе гэхийн зуургүй, нүд ирмэхийн зуур, хуй салхи мэт, шувуу шиг, жигүүртэй юм шиг, сум шиг** гэх зэргийн үгсийг ашиглахаас гадна **цай чанах зуур, тамхи нэрэх хооронд, морь эмээллэх зуур, нүдний хор гаргах хооронд** гэж адилтган харьцуулах нь олонтой. Жишээ нь:

“Юун олон адуу хаанаас гараад ирэв ээ гэж Занабазарыг дуугарахад, Дархан эмээлээ морин дээрээ шидэж, **нүд ирмэхийн зуур** мордоод адууны хойноос давхин одов.” С.Эрдэнэ “Занабазар” гэх буюу эсхүл “Цэрэндашийг Жамсрангийн ороход Хүүжий, Балжмаа хоёр **цай амсахын зуургүй** байцаан шалгаав.” (Д.Намсрай “Бор галуутайн талд”) хэмээн хэлцэнэ.

Эзлэхүүн багтаамж, овор хэмжээг илэрхийлсэн олон үг байдаг бөгөөд хамгийн жижиг зүйлийг хумхын тоос, хумсын чинээ гээд асар томыг тэнгэр газар, уул хадтай, мөн мал, ахуй

амьдралд хэрэглэдэг зүйлтэйгээ жишин үзүүлдэг байжээ. Жишээ нь:

“Тэр дугуй боовыг би Жандаш гэдэг бэлтэй айлд сар шинээр гэрийн ерөөл тавьж олдог болсонд хүүхдүүд атаархах боловч тасгийн хүүхдийн тоогоор **хумсын чинээ** хэлтэлж өгөөд санааг амраана.” (Д.Пүрэвдорж “Улаан гэрийн хоригдол”) гэх буюу “...Хангай говийн хооронд халхын **уудам** нутаг

Хар бага наснаас **хөндлөн гулд** давхисан газар...” (Д.Нацагдорж “Миний нутаг”) мэтээр уран яруу дүрсэлсэн шүлэг зохиол, хэллэг хэлц арвин юм.

Басхүү ус ундаа, цай цүй, айраг цагаа, архи дарс мэтсийн шингэн зүйлийг **агуулах хөхүүр, тогоо, данх, домбо, аяга, шанага, халбага зэрэг сав суулгаар, гарын алганы хонхор, амны балга зэргийн багтаамжаар, үйрмэг бутархайг шуудай сав, алга атга, атга чимх** гэхчлэн олон янзаар жишин хэмждэг билээ. Жишээ нь:

“Архи хэмээх хатуу ундыг **жүнз** гэгч өчүүхэн юманд хийж, хуруу гарган, хуалан бие биеэ шахан уулгана.” (Д.Намдаг “Цаг төрийн үймээн”) гэх буюу “Тэр шувуу өвлийн хүйтэнд өлсөнө гэж, хаврын хатууд харшина гэж хайртай бэтгэ гүендээ **чимх будаа** чихэж, **атга будаа** агуулсан юм санжээ.” (“Бэтгэлжин бор шувуу”) үлгэрт өгүүлжээ.

*Эцэст нь нэгтгэн дүгнэвээс*, монголчуудын олон зуун жилийн тэртээгээс ахуй амьдралынхаа өвөрмөц онцлогт тохируулан хэрэглэж ирсэн дээрх хэмжээсүүд бол физик, математик, философи, хими, өөр бусад шинжлэх ухааны нарийвчилсан тоон ухагдахуунтай дүйцээд зогсохгүй, тэдний хэл хэлэхүй, сэтгэхүй сэтгэлгээ, аж төрөх ёс, түүх соёл, танин мэдэхүйн онцгой чадвар түүнтэйх амьдрал ахуйн уялдаа холбоо басхүү өөр аль ч улс оронд дахин давтагдашгүй билээ.

### Abstract

The measurements invented and used by Mongolians for many centuries already overcame detailed measurement concepts in physics, mathematics, philosophy, chemistry and other field of science. These measurements represent the unique lifestyle of Mongolians as well as their language, way of thinking, history, and culture.

### Номзүй

- Догмид Б. 2004. *Зохиолын түүвэр*. Улаанбаатар.
- Лонжид З. 2000. *Монголчуудын хэмжээ илэрхийллийн талаар нэхэн эргэцүүлэхүйн учир*. Улаанбаатар.
- Монгол Ардын Аман Зохиол. “Бэтгэлжин бор шувуу” үлгэр. 1971. Улаанбаатар.
- Монгол Ардын Аман Зохиол. “Ногоон Дарь эхийн тууж”. 1971. Улаанбаатар.
- Намдаг Д. 1977. *Цаг төрийн үймээн*. Улаанбаатар.
- Намсрай Д. 1992. *Бор галуутайн талд*. Улаанбаатар.
- Нацагдорж Д. 2006. *Зохиолын түүвэр*. Улаанбаатар.
- Пүрэвдорж Д. 2009. *Улаан гэрийн хоригдол*. Улаанбаатар.
- Пүрэвжанцан А. 1998. *Монголчуудын хэмжээ илэрхийллийн товч тайлбар толь*. Улаанбаатар.
- Пүрэвжанцан А. 2017. *Монголчуудын хэмжээ илэрхийлэл*. Улаанбаатар.
- Түдэв Л. 1991. *Эрхий дарам зай*. Улаанбаатар.
- Цэнджав До. 2015. *Хулангийн цавчаал*. Улаанбаатар.
- Эрдэнэ С. 1982. *Амьдралын тойрог*. Улаанбаатар.
- Эрдэнэ С. 1988. *Занабазар*. Улаанбаатар.